



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 03 сарын 23-ны  
өдрийн 6185 дугаарт бүртгэв.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 82


Улаанбаатар хот

Г “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн”  
дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх  
журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9, 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

1518000142



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн  
дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх  
журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9, 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХ, ТАЙЛАН, МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээл болон барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцохтой холбогдох харилцааг зохицуулна.

### Хоёр.Бүртгэлийн дэвтэр хөтлөх

2.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь зээл, барьцаа, батлан даалтын гэрээ байгуулах, өөрчлөлт оруулах тухай бүр болон гэрээний хэрэгжилттэй холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг цахим системд холбогдсон программ хангамж ашиглан энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан загварын дагуу цахим бүртгэлийн дэвтэр (цаашид “бүртгэлийн дэвтэр” гэх)-т бүртгэж, бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтөлнө.

2.2.Бүртгэлийн дэвтэрт заасан барьцаа хөрөнгийн зургийг бүтэн, тод, гаргацтай, тухайн барьцаа хөрөнгийг илэрхийлэх загвар, марк, дугаар, жин, онцлог шинжийг харуулсан байдлаар авч цахим системд оруулна.

2.3.Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэх этгээдийн бүртгэлийн дэвтрийн нэгдсэн мэдээллийн сан Санхүүгийн зохицуулах хороонд байршина.

### Гурав.Тайлан, мэдээ

3.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр өссөн дүнгээр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэх байгууллагад цахимаар хүргүүлнэ:

3.1.1.энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан зээлийн нэгдсэн тайлан;

3.1.2.энэ журмын гуравдугаар хавсралтад заасан санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлт;

3.1.3.энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан үүрэг гүйцэтгэсэн зээлийн мэдээ;

3.1.4.Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шаардлагатай бусад мэдээлэл.

3.2.Энэ журмын 3.1-д заасан тайлан, мэдээний ирц, бүрэн бүтэн байдалд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэх байгууллага хяналт тавина.

3.3.Харьяалах бүртгэх байгууллага нь хагас, бүтэн жилийн тайлан, мэдээг хянан дараа сарын 30-ны өдрийн дотор баталгаажуулна.



“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлийн дэвтэр хөтлөх журам”-ын хоёрдугаар хавсралт

ЗЭЭЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

0000/CC/ӨӨ

/төгрөгөөр/

№	Барьцааны ангилал	Нийт зээлийн эхний үлдэгдэл		Нийт олгосон зээл			Нийт төлөгдсөн зээл		Нийт зээлийн эцсийн үлдэгдэл		
		Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Хүү /сараар/	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Хүү /сараар/
		Нийт	-	-	-	-	#DIV/0!		-	-	-
1	Тээврийн хэрэгсэл									-	
2	Цахилгаан хэрэгсэл									-	
3	Тавилга эд хогшил									-	
4	Үнэт эдлэл									-	
5	Орлого									-	
6	Эзэмших эрх									-	
7	Мал									-	
8	Тоног төхөөрөмж									-	
9	Бараа материал, хувцас хэрэглэл									-	
10	Бусад									-	

\* Эзэмших эрх гэдэгт хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх хамаарна.

\* “Бусад” ангилалд энэхүү нэгдсэн тайлангийн “барьцааны ангилал” хэсэгт дурдагдаагүй барьцаа хөрөнгүүд хамаарна.

\*тайлант хугацаанд олгосон болон төлөгдсөн нийт зээлийг хамааруулна.

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн  
бүртгэлийн дэвтэр хөтлөх журам”-ын гуравдугаар хавсралт

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
<b>1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>1. ӨР ТӨЛБӨР</b>	
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1.1	ЗЭЭЛ
	Бэлэн мөнгө		Банкнаас авсан зээл
	Харилцахад байршуулсан		Зохицуулалттай хуулийн этгээдээс авсан зээл
	Хадгаламжид байршуулсан		Зохицуулалттай хувь хүнээс авсан зээл
1.2	НИЙТ ЗЭЭЛ	1.2	ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ
	Хугацаандаа байгаа (20 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн)	1.3	БУСАД ӨР ТӨЛБӨР
	Хугацаа хэтэрсэн (21-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн)	<b>2. ЭЗДИЙН ӨМЧ</b>	
1.3	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ	2.1	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ
1.4	БУСАД ХӨРӨНГӨ	2.2	ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ
<b>2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			Тухайн үеийн ашиг/алдагдал
2.1	ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)		Хуримтлагдсан ашиг/алдагдал
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө		
	(Хуримтлагдсан элэгдэл)		
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	
<b>ЗАРДАЛ</b>		<b>ОРЛОГО</b>	
	Цалингийн зардал		Зээлийн хүүгийн орлого
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал		Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого
	Үйл ажиллагааны зардал		Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого
	Түрээсийн зардал		Нэмэгдүүлсэн хүүгийн орлого
	Бусад зардал		Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого
	Орлогын албан татварын зардал		Бусад хүүгийн орлого
			Бусад орлого
		<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>	
			Зээлийн ҮНДСЭН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Зээлийн ХҮҮГИЙН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Барьцаа хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгөн дүн

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн  
бүртгэлийн дэвтэр хөтлөх журам”-ын дөрөвдүгээр хавсралт

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

№	Зээлдэгчийн				Зээл					Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэхэмжилсэн дүн	Үүрэг гүйцэтгэсэн			
	Овог, нэр	Регистрийн н дугаар	Харьяала л /хот, аймаг/	Харьяала л /сум, дүүрэг/	Олгосон огноо	Олгосон дүн	Төлөгдсөн дүн	Үлдэгдэл дүн	Хугацаа хэтэрсэн хоног		Огноо	Дуудлага худалдаагаар зарагдсан дүн	Төлөгдсөн дүн	Эцсийн үлдэгдэл
	-	Нийт дүн			xxx	-	-	-	xxx		-	xxx	-	
1														
2														

\*хугацаа хэтэрсэн хоногийг гэрээнд заасан төлж дуусах огнооноос хойш тоолно.

